

Үндсэн хууль...

Эдүгээ Үндсээ хуулиа хэрхэн засварлах тухай яриа хөөрөө, маргаан мэтгэлцээн ид хүчээ авч байна. Энэ дунд шинжилгээ судалгаанд суурилсан, голч санаа, гоё санал олонтаагийн зэрэгцээ заримдаа байгаа олохгүй, халих, самууран тэнүүчлэх хүртэл байдал багагүй ажиглагдаж буй нь байх л зүйл биз. Гэхдээ, эцсийн эцэст Үндсэн хууль бол зөвхөн “ихэс дээдсийн ч бус нийт ард түмний бүтээл” гэж нэгэн номт мэргэний айлдсанаар болох болтугай гэмээр байна. Ийм эцэг хууль бол “элдэв бүхнийг чихээд байх шуудай биш” хэмээн өөр нэгэн ухаантан учирласнийг ч бид санаж явах нь зөв биз ээ.

Х.Бэхбат

\* \* \*

- The Constitution only gives people the right to pursue happiness. You have to catch it yourself.

Benjamin Franklin

- People tend to forget their duties but remember their rights.

Indira Gandhi

- The secret of Freedom lies in educating people, whereas the secret of tyranny is in keeping them ignorant.

Maximilien Robespierre

- Without liberty, law loses its nature and its name, and becomes oppression. Without law, liberty also loses its nature and its name, and becomes licentiousness.

James Wilson

- It will not be denied that power is of an encroaching nature and that it ought to be effectually restrained from passing the limits assigned to it.

James Madison



**Б.Батхишиг**

Эдийн засгийн ухааны доктор, профессор

# ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлэх замаар түүний бие даасан байдлыг хангах, үүний тулд олборлох, боловсруулах салбарыг хосолсон эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, зах зээлийн харилцааг төрийн зохицуулалттай зохистой хослуулах, хүн аюулгүй, амгалан амьдрах байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой нөхцөл бүрдүүлэх явдал юм.

Эдийн засгийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт:

- 1/ Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бүрдүүлэх;
- 2/ Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого хэрэгжүүлэх;
- 3/ Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг хангах;
- 4/ Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын аюулгүй байдлыг хангах;

5/ Гадаад худалдаа, интеграцийн зохистой бодлого хэрэгжүүлэх зэрэг багтана.

Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бүрдүүлэх тухай олон жил ярьж байгаа боловч өнөөдөр уул уурхай голлосон эдийн засгийн өрөөсгөл бүтэцтэй хэвээр байна. Эдүгээ уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 22.6, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 56.1, экспортын 89.2 хувийг эзэлж байна. Гэтэл боловсруулах үйлдвэрлэл дотоодын нийт бүтээгдэхүүний 10.2, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 34.9 хувийг эзэлж байна. Тэгэхдээ уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин доогуур, дээд тал нь баяжмал хэлбэрээр гаргаж байгаа. Түүнчлэн тус салбарын бүтээгдэхүүний тээврийн болоод эрчим хүч, усны асуудал хүнд хэвээр байна.

Тус салбар нь нөхөн сэргээгдэхгүй нөөц дээр ажилладаг, түүхий эд, бүтээгдэхүүнийх нь үнэ дэлхийн зах зээлийн байдлаас болоод үргэлж савалж байдаг, мөн нэмүү өртөг бага шингэсэн бүтээгдэхүүний экспорт голлож байгаа, дэд бүтэц муу, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах асуудал шийдэгдээгүй зэрэг олон сул асуудалтай учир эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад учир дутагдалтай юм.

Иймд юуны өмнө уул уурхайд шинэ технологи нэвтрүүлж, түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, дэд бүтцийг өргөтгөх замаар түүнийг олон арван жил тогтвортой ажиллах, илүү их ашиг орлого авчрах нөхцлийг бүрдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг эрс багасгах шаардлагатай юм.

Үүний зэрэгцээ боловсруулах үйлдвэрлэл, юуны түрүүнд

малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг шинэчлэн хөгжүүлж, эдийн засаг дахь түүний эзлэх хувь хэмжээг дор хаяж хоёр дахин өсгөх хэрэгтэй. Ингэснээр уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуй гурав манай эдийн засгийн тулгын гурван чулуу болох бөгөөд үүн дээр дэд бүтэц, аялал жуулчлал нэмэгдэн олон тулгуурт эдийн засаг хөгжих юм.

“Дэд бүтцийн салбарын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлж, хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашгийг шалгуур болгоно.”<sup>1</sup> гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан. Гэтэл манай улсыг умард ба өмнөд хөрштэй холбосон ачаа тээврийн гол зам болсон төмөр замын өнөөгийн байдал аюулгүй байдлын шаардлагад нийцэхгүй байна. 1111 км тус замын 400 км орчим хэсэгт дэр модыг солих, бусад засвар хийх шаардлагатай болжээ. 2018 оны 8 дугаар сард болсон төмөр замын осол үүнийг дахин нотоллоо. Энэ зам нь гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулахад нэг гол зам нь болох учир аюулгүй байдлыг дээд зэргээр хангах учиртай.

Манай улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтцийг харахад гол нь уул уурхайн салбарт төвлөрч, бусад салбарт бага хэмжээтэй байна. Уул уурхайн салбарт ажиллаж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд уул уурхайн эрдэс түүхий эдийг боловсруулалтгүй болон хагас

боловсруулан гадаадад гаргаж байгаагийн улмаас ихээхэн хэмжээний орлого, ашиг олох боломжийг алдаж байна.

Мөн гадаадын зарим хөрөнгө оруулагч манай улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулж, төсөл хэрэгжүүлж байгаад түүнийгээ гадаадын өөр компанид худалддаг явдал гарсаар байна. Ялангуяа Хойд Америкийн компаниуд уул уурхайн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө өмнөд хөршийн компаниудад зарах явдал анхаарал татаж байна. Энэ тухай тус номын 4 дүгээр бүлэгт өгүүлсэн.

Энэ нь яваандаа “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтлана”<sup>2</sup> гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасантай зөрчилдөх нөхцөл байдал үүсгэхийг үгүйсгэх аргагүй.

Иймд хайгуулын болон ашиглалтын лиценз, компанийн хувьцааг худалдах явдлыг хуулиар зохицуулах шаардлагатай. Гадаадын аж ахуйн нэгж, хуулийн этгээд уул уурхайн хайгуулын юмуу ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан бол түүнийгээ зориулалтын дагуу ашиглахаас биш хоорондоо зарж борлуулах эрхгүй байх ёстой. Хэрэв зарж борлуулах шаардлагатай бол гагцхүү улсад буцааж өгөх учиртай гэдгийг давтан тэмдэглэе.

Манай улсын статистикийн эмхэтгэлд гадаадын шууд

хөрөнгө оруулалтын нийт хэмжээг эдийн засгийн салбар болон хөрөнгө оруулсан улсаар харуулсан тоо баримт алга. Уг нь энэ тоо баримтыг байнга гаргаж, нийтэлж байх нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэгтэйсэн билээ.

“Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна.”<sup>3</sup> гэж үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан. Гэтэл манай улсын гадаад өрийн нийт хэмжээ 2018 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 27,9 тэрбум ам. доллар болсноос Засгийн газрын өр 7,2 тэрбум ам. доллар буюу 25.8 хувь байна. Үүн дээр Төвбанкны зээлийг нэмбэл улсын өр 9.4 тэрбум ам. доллар буюу нийт гадаад өрийн 33.7 хувийг эзэлж байна.

Хувийн хэвшлийн гадаад өр нийтдээ 18.5 тэрбум ам. доллар буюу нийт гадаад өрийн 66.3 хувийг эзэлж байна. Монгол Улсын Засгийн газрын өр 2012 оны эцэст 2,2 тэрбум ам. доллар байсан бол 2017 оны эцэст 7,3 тэрбум ам. доллар болж, 3.3 дахин өсчээ.

2017 оны байдлаар манай улсын нийт гадаад өрийн хэмжээ нь мөн оны дотоодын нийт бүтээгдэхүүний 251.4 хувьтай тэнцэж байв. Өөрөөр хэлбэл, нийт гадаад өр дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээнээс 2.5 дахин их байна

Гадаад өрийн энэхүү хэмжээ нь олон улсын аргачлалаар ямар эрсдэлтэй байгааг авч үзэхэд

1 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.1.4.

2 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.2.2.

3 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.3.2.

манай улс 2017 оны байдлаар өрийн тогтвортой байдлын 2 индикатор үзүүлэлтийг хангаагүй, 1 үзүүлэлт шалгуур үзүүлэлттэй бараг тэнцүү байгаа нь өрийн зохистой түвшин алдагдсан, өрийн дарамтад орох эрсдэлтэй байгааг харуулж байна. Олон улсын жишгээр 5 үзүүлэлтээс 3 нь хангагдаагүй бол тухайн улсыг өрийн дарамтад орох эрсдэлтэй гэж үздэг.

Түүнчлэн бондын мөнгийг улсын эдийн засагт нэн хэрэгтэй, ач холбогдолтой томоохон төслүүдэд төвлөрүүлэн зарцуулахын оронд янз бүрийн олон жижиг төсөлд цацан олгосон тухай тус номын 4 дүгээр бүлэгт өгүүлсэн. Товчоор хэлбэл, гадаад өрийн хэмжээ эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж мэдэхүйц түвшинд хүрчээ. Одоо арвилан хэмнэлтийг дээд зэргээр хийж, эдийн засгийн бүхий л нөөц бололцоог дайчлан гадаад өрийг эдийн засаг, ард иргэдийн амьдралд дарамт багатайгаар төлж барагдуулах асуудал тулгарч байна.

“Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ.”<sup>4</sup> гэж үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан. Манай улсын импортын нэг жилийн хэрэгцээ сүүлийн 3 жилээр авч үзэхэд 3.8-4.3 тэрбум ам. доллар байв. Тэгэхээр манай улсын гадаадын валютын албан нөөц энэ хэмжээнээс дээш, өөрөөр хэлбэл, 4 тэрбум ам. доллараас

4 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.3.3.

багагүй байх ёстой аж. Гэвч Монголбанкны мэдээлж буйгаар 2016 оны 12 дугаар сард манай улсын гадаад валютын албан нөөц 1.3 ам. доллар болж буурсан бөгөөд 2017 оны 12 дугаар сар гэхэд 3 тэрбум ам. доллар болж өсчээ.

Үүнээс үзэхэд гадаад валютын албан нөөц эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хэмжээнд хүрээгүй, зарим үед эрс буурч эрсдэлтэй хэмжээнд хүрч байжээ. Иймд цаашид гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлж, шаардлагатай хэмжээнд хүргэхийн тулд алтны талаар онцгой бодлого явуулах нь зүйтэй гэж үзэж байна. Алт бол хэзээ ч үнэ цэнээ алдахгүй ховор бөгөөд үнэт металл. Бас манай улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх нэг чухал эх сурвалж. Иймд цаашид алтны талаарх төрийн бодлогыг өөрчилж, хөрөнгө хүч муу гэдгээр далимдуулан нөөц ихтэй сайн ордуудаа гадаадын компаниудад өгч ашиглуулах биш, өөрсдөө олборлох зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Энэ тухай тус номын 3 дугаар бүлэгт өгүүлсэн тул энд товчлов.

“Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна.”<sup>5</sup> хэмээн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан.

5 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.4.1.

Гэсэн хэдий ч манай улсад ажиллаж буй дотоод, гадаадын уул уурхайн үйлдвэрлэлийн газрууд эрдэс түүхий эдийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар ахиц гаргахгүй байна. Тухайлбал, зэсийн баяжмалыг хайлуулж, цэвэр зэс үйлдвэрлэх нь ашигтай тухай олон жил ярьж байгаа ч одоо хүртэл хэрэгжүүлж эхлээгүй байна. Үүний улмаас манай улс уул уурхайн түүхий эдийн хавсарга орон хэвээр байна.

“Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээг бүрэн хангана. Үнийн хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.”<sup>6</sup> гэж үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дурьдсан. 2018 онд Дорноговь аймагт газрын тос боловсруулах үйлдвэрийн шав тавьсан нь энэ заалтыг хэрэгжүүлэх чиглэлд том алхам болсон. Одоо гагцхүү уг үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь барьж дуусгах, түүхий нефтийн хангамжийн асуудлыг шийдэх нь чухал байна.

“Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.”<sup>7</sup> хэмээн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан. Энэ үзэл баримтлал батлагдсан 2010 онд манай улсын экспортын

6 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.4.3.

7 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.5.1.

84.8 хувь нь БНХАУ руу гарч байсан бол 2017 онд 85.6 хувь болжээ. 7 жил өнгөрөхөд уг үзэл баримтлалын энэ заалт огтхон ч хэрэгжээгүй байна. Мөн 2010 онд манай экспортын 2.8 хувийг ОХУ руу гаргадаг байсан бол 2017 онд энэ нь 1.1 хувь болж бүүр багасчээ.

Энэ мэтчилэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дахь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилтуудын нэлээдийг хэрэгжүүлж чадахгүй байна. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангахгүй бол үндэсний аюулгүй байдлыг хангаж чадахгүй. Үндэсний аюулгүй байдал нь

- Оршин тогтнохуйн аюулгүй байдал;
- Эдийн засгийн аюулгүй байдал;
- Дотоод аюулгүй байдал;
- Хүний аюулгүй байдал;
- Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал;
- Мэдээллийн аюулгүй байдлаас бүрдэх бөгөөд эдгээрийг харилцан уялдаатай хангаснаар үндэсний аюулгүй байдал бэхжинэ. Эдгээр дотроос эдийн засгийн аюулгүй байдал онцгой ач холбогдолтой бөгөөд түүнийг хангах нь үндэсний аюулгүй байдлыг хангахад төдийгүй улсын хөгжлийг хурдасгахад шийдвэрлэх үүрэгтэй юм. Энэ тухай академич С.Нямзагд бичихдээ “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангаагүй цагт улс төр, нийгмийн аюулгүй байдал баталгаажихгүй. Мөн эргээд улс төр, нийгмийн тогтвортой байдал нь эдийн засгийг хөгжүүлэх нэн таатай нөхцөл болдог тэр утгаараа уг асуудлыг төр засгийн бодлогын төвд байлгах асуудал оор аргагүй бөгөөд хэрэв анхаарлаа сулруулбал улс

орон маань тусгаар тогтнолоо ч алдаж болохсон билээ.”<sup>8</sup> гэж анхааруулжээ.

Манай улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд сулавтар туссан асуудал бол хүн амын орлогын ялгааг багасгах асуудал юм. Уг үзэл баримтлалд “дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ.”<sup>9</sup> гэж дурьдсанаас өөр тодорхой зорилт алга. Хүн амын орлогын ялгааг багасгах асуудал бол эдийн засгийн засгийн аюулгүй байдал болон дотоод аюулгүй байдал, тухайлбал, нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Ийм ч учир бид тус номын 2 дугаар бүлэгт уг асуудлыг тусгайлан авч үзсэн.

Иргэдээ ажлын байраар хангахаас гадна хөдөлмөрийн үнэ цэнийг, өөрөөр хэлбэл, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй бол ажиллах хүчний хангалтад муугаар нөлөөлж байна. 2017 оны эхний байдлаар гадаадад манай улсын 144483 иргэн байнга оршин сууж байгаагийн 26214 нь суралцах визтэй, бусад нь буюу 81.9 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа тухай дээр өгүүлсэн. Цаашид энэ тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь анхаарах асуудал мөн.

Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн ханшийг хамаагүй унагах нь эдийн засагт төдийгүй нийгмийн олон асуудалд хортой нөлөө үзүүлдэг байна. Энэ нь бас манай эдийн засгийн хэмжээг хиймлээр өсгөж, бодит

эдийн засаг ба хиймэл эдийн засаг хоёрын хоорондын ялгааг нэмэгдүүлж байна. Жилээс жилд дотоодын нийт бүтээгдэхүүн, улсын төсвийн хэмжээ өсөж байгаа мэт харагдавч үнэн хэрэгтээ ханш нь унасан төгрөгөөр илэрхийлэгдсэн болохоор хиймлээр өссөн болж таарч байна. Хэрэв тэдгээрийг ам. доллараар илэрхийлбэл хэмжээ нь төдий л өсөөгүй гарна. Төгрөгийн ханш унахын хамгийн хортой нөлөө нь бидний төгрөгөөр авсан цалин, тэтгэвэр, төгрөгөөр хийсэн хадгаламжийн үнэ цэнийг бууруулж байгаа явдал юм.

Иймд “Мөнгөний бодлогын үр дүнг дээшлүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах, хөрвөх чадварыг сайжруулж, тогтворжуулна.”<sup>10</sup> гэсэн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дотоодын цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлогыг тууштай баримтлах хэрэгтэй.

Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж мэдэх өөр нэг ноцтой асуудал бол далд эдийн засаг тэлж, албан бусаар ажил эрхлэгчид олширч, үйлдвэрлэн бүтээх биш, дамлан, дамжуулан хуваарилах эдийн засгийн гажууд бүтэц бүрэлдэх явдал юм.

/үргэлжлэл нь дараагийн дугаарт/

8 С.Нямзагд, Үндэсний эдийн засгийн стратегийн удирдлага, боть 2, Улаанбаатар, 2001, 269 дэх тал

9 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.1.9.

10 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт, 3.2.3.4.



Х.Аюурзана


Элчин сайд асан, судлаач

# БНХАУ-ЫН ДАРГА СИ ЖИНЬПИННИЙ ОХУ-Д ХИЙСЭН ТӨРИЙН АЙЛЧЛАЛЫН ТУХАЙ

БНХАУ-ын дарга Си Жиньпин энэ оны 6 дугаар сарын 5-7-нд ОХУ-д төрийн айлчлал хийж, улмаар Санкт-Петербург хотод болсон эдийн засгийн форумд оролцлоо. Хоёр орны удирдагч Владимир Путин, Си Жиньпин нар сүүлийн зургаан жилийн дотор 30 гаруй удаа уулзжээ. Зөвхөн Хятадын дарга Си Жиньпин 2013 оноос хойш ОХУ-д 8 удаа айлчилсан байна.

Хятадын дарга ОХУ-д маш өргөн бүрэлдэхүүнтэйгээр айлчлал хийсэн бөгөөд түүний айлчлалын бүрэлдэхүүнд албаныхнаас гадна бизнесийн 1000 гаруй төлөөлөгчид багтжээ. Мөн энэхүү айлчлал нь БНХАУ, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойтой давхцаж байгаа нь айлчлалын агуулгыг улам баялаг болгожээ.

Айлчлалын үеэр Владимир Путин, Си Жиньпин нар ганцаарчилсан уулзалт, өргөтгөсөн хэлэлцээ хийж, хоёр орны стратегийн түншлэлийн



харилцааны болон олон улсын харилцааны өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцэж, хамтарсан мэдэгдэл гаргалаа.

Айлчлалын үеэр 30 орчим гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж, “Хоёр орны бүх талын түншлэлийн харилцаа ба шинэ эрин үед стратегийн хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх тухай” мэдэгдэл, мөн “Орчин үед хоёр талын хамтын ашиг сонирхолыг

хөндсөн олон улсын харилцааны асуудал, стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх тухай” мэдэгдэл гэсэн хоёр хамтарсан мэдэгдэл гаргав.

Орос, Хятадын харилцаа ийнхүү улам ойртон нягтарч цэцэглэн хөгжиж байгаа нь АНУ-ын зүгээс тус хоёр орны эсрэг явуулж буй бодлоготой холбоотой гэж шинжээчид үзэж байна. Нөгөө талаар Владимир

Путин, Си Жиньпин нарын хувийн найрсаг харилцаа ч үүнд нөлөөлсөн гэж үзэж болох байна.

“ОХУ бол миний зочлох хамгийн дуртай гадаадын орон, Ерөнхийлөгч В.Путин миний хувьд хамгийн дотны найз, сайн хамтрагч, бидний харилцаа өндөр итгэлцэл дээр тогтдог, Орос, Хятадын стратегийн нягт хамтын ажиллагаа, хоёр орны харилцааны өндөр түвшин үүнийг харуулж байна, хамгийн гол нь БНХАУ, ОХУ-ын харилцааны стратегийн ач холбогдолтой асуудалд бид нэгдмэл байр суурьтай, мөн хоёр улсын харилцааг удаан хугацаанд гүнзгийрүүлэн хөгжүүлэх нийтлэг хүсэл сонирхолтой байдаг” гэж Хятадын дарга Си Жиньпин хэлсэн үгэндээ онцлон тэмдэглэжээ.

“Хоёр орны харилцаа урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрсэн, гэхдээ хоёр тал харилцаагаа улам бататгана” гэж Ерөнхийлөгч В.Путин бас мэдэгдсэн. Ерөнхийлөгч В.Путин Си Жиньпин даргыг дагуулан Петербург хотоор аялж, хотыг танилцуулсан нь ОХУ-ын төрийн ёслолын журамд байгаагүй зүйл бөгөөд энэ нь ОХУ-ын ерөнхийлөгчөөс БНХАУ-ын даргад үзүүлсэн өндөр хүндэтгэл, В.Путин Си Жиньпин нарын ойр дотно нөхөрсөг харилцааны илэрхийлэл гэж Оросын хэвлэлүүд онцлон тэмдэглэж байлаа.

АНУ болон Европын орнууд ОХУ-ын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авч, АНУ-аас БНХАУ-ын эсрэг “худалдааны дайн” өрнүүлж байгаа нь

Орос, Хятадын харилцааг улам ойртуулж нягтруулахад хүргэсэн. Үнэхээр сүүлийн жилүүдэд Орос, Хятадын харилцаа эрчимтэй хөгжиж байна.

Хоёр улсын худалдааны эргэлт 2018 онд 25 хувиар нэмэгдэж, 108 тэрбум ам.долларт хүрсэн байна. Түүнчлэн ОХУ дахь Хятадын хөрөнгө оруулалт хоёр дахин нэмэгдсэн байна. Хятад Улс ОХУ-ын гадаад худалдаанд тэргүүлэх байр эзэлж байна. Энэ нь “БНХАУ бол Оросын эдийн засгийн чухал хамтрагч гэдгийг илтгэж байна” гэж ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин мэдэгдсэн.

Хоёр орны эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. ОХУ Хятадад нефтийн бүтээгдэхүүн нийлүүлэлтээрээ тэргүүлж, өнгөрсөн жил 67 сая тонн түүхий эдийг тээвэрлэсэн байна.

Өнгөрсөн жил ОХУ-ын 2.2 сая жуулчид Хятадад зорчсон бол Хятадын 1.7 сая жуулчин Орост очжээ.

В.Путин сэтгүүлчидтэй уулзахдаа, Орос, Хятад улсууд хоёр талын худалдаандаа үндэснийхээ валютаар (рубль, юаниар гэсэн үг) тооцоо хийхээ өргөжүүлж, банкны үйлчилгээгээр тасралтгүй хангахаар тохиролцож хэлэлцээр байгуулснаа зарласан.

Айлчлалын хүрээнд гарын үсэг зурсан гэрээ хэлэлцээрүүдээс онцлон тэмдэглэхэд «Росатом», Хятадын цөмийн аж үйлдвэрийн корпорацийн хооронд “Сюй Дапу”-ийн Атомын цахилгаан станцын эрчим хүчний 3-4 дүгээр блоккийг байгуулах гэрээнд гарын үсэг зурсан байна. Мөн Оросын

шууд хөрөнгө оруулалтын фонд, Хятадын хөрөнгө оруулалтын корпорацийн хооронд “Орос-Хятадын шинжлэх ухаан, техникийн инновацын фонд байгуулах” нэг миллиард долларын гэрээнд гарын үсэг зуржээ.

“Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын байдал уналттай байгаа нөхцөлд ийм үр дүнд хүрнэ гэдэг амаргүй. Хоёр улс эрчим хүч, тээвэр, хөдөө аж ахуй, агаарын тээвэр болон бусад салбарт хамтарсан томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна” гэж Си Жиньпин дарга онцлон тэмдэглэсэн байна.

Хоёр тал яриа хэлэлцээнийхээ үеэр орчин үеийн олон улсын харилцааны стратегийн чухал асуудлаар нэгдмэл байр суурьтай гэдгээ харилцан тэмдэглэсэн юм.

Хоёр талын удирдагчид Солонгосын хойгт энх тайван тогтоохоос өөр сонголт байхгүй гээд энэ асуудлаар хоёр тал нэгдмэл байр суурьтай байгаагаа илэрхийлсэн. Мөн “ОХУ, Хятад хоёр Сирийн хямралыг энх тайван замаар шийдвэрлэхэд хамтран ажиллаж, Венесуэлийн нөхцөл байдлыг тогтвортой болгохын төлөө байгаагаа илэрхийлж, Ираны цөмийн хөтөлбөрийн талаарх хамтарсан, цогц үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно” гэдгээ хоёр тал онцлон тэмдэглэсэн байна.

Хоёр талын хамтарсан мэдэгдэлд “Орос, Хятад хоёр зэвсэгт хяналт тавих, зэвсэг хураах, үл дэлгэрүүлэх талаар байгуулсан гэрээ хэлэлцээрүүдээр тогтоосон олон улсын аюулгүй байдлын системийг эвдэхийг хүлээн

зөвшөөрөхгүй” гэсэн зарчмын байр сууриа илэрхийжээ.

Талууд НҮБ, ШХАБ, БРИКС, ЕАЭС, “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд болон бусад олон улсын тавцанд хамтын үйл ажиллагаагаа улам нэмэгдүүлэх болсноо мэдэгдсэн.

“Одоо дэлхий дахин их өөрчлөлтийг даван туулж байгаа. Ялангуяа, эрх мэдэл, хүчирхийллийн бодлого эрчимжиж байна. Бид энх тайван, хөгжилд хүрэх урт, хэцүү замыг туулна. Хятад, Орос улс олон улсын хамтын нийгэмлэгийн хамтаар НҮБ-ын ивээл дор олон улсын тогтолцоог хамгаалж, “халуун цэгт” байгаа асуудлаар улс төрийн зохицуулалтад хүрэхийг идэвхтэй дэмжинэ. Олон улсын хурцадмал нөхцөл байдалд эерэг нөлөө үзүүлж, хүн төрөлхтний ирээдүйд шинэ хувь нэмэр оруулахын төлөө ажиллана” гэдгээ Си Жиньпин дарга мэдэгдлээ.

Си Жиньпиний айлчлалын үеэр хоёр орны удирдагч Хятад, Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулсан фото зургийн үзэсгэлэнг үзэж, хоёр орны эв найрамдлын бэлгэдэл болсон хоёр панда бүхий шинэ павильоныг Москвагийн амьтны хүрээлэнд нээх ёслолд оролцсон. Энд нэг зүйлийг тэмдэглэхэд Хятад улс пандааг гадаад орнуудад бэлэглэдэг байснаа больж, зөвхөн найрсаг харилцаатай орнуудад тодорхой хугацаагаар түрээсээр өгдөг болсон байна.

Си Жиньпин, Владимир Путин нар АНУ-ын худалдааны дайн, эдийн засгийн хориг

арга хэмжээний эсрэг хамтдаа тэмцэнэ гэдгээ мэдэгдлээ. “Үүссэн асуудлуудыг үр дүнтэйгээр шийдвэрлэхийн тулд цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хамтын ажиллагааны хүрээгээ тэлж, харилцан хөрөнгө оруулалтын түвшинг нэмэгдүүлж, худалдаа, хөрөнгө оруулалтын журмыг хөнгөвчлөх хэрэгтэй” гэдгийг Си Жиньпин онцлон тэмдэглэв. Оросын Ерөнхийлөгч В.Путин хоёр талын аж үйлдвэрийн хамтын ажиллагаа улам өргөжин хөгжиж байгааг дурдсан бол хоёр тал олон улсын тээврийн коридоруудыг хамтран хөгжүүлэхийн чухлыг Си Жиньпин дарга онцолсон байна.

Си Жиньпин дарга айлчлалынхаа хүрээнд ОХУ-ын Санкт-Петербургийн олон улсын эдийн засгийн форумд оролцсон юм. Энэ жил 23 дахь удаагаа зохион байгуулагдаж буй форумд Хятадын дарга Си Жиньпинээс гадна НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Гутерреш, Болгар, Словак, Армения зэрэг орны төр, засгийн тэргүүнүүд, олон улсын нөлөө бүхий компаний төлөөлөгчид оролцлоо. Дэлхийн эдийн засгийн томоохон арга хэмжээнүүдийн нэг болох энэхүү чуулга уулзалт нь энэ жил “Тогтвортой хөгжлийн асуудлыг тодорхойлох нь” уриан дор болжээ.

Хятад улсын дарга Си Жиньпиний энэхүү айлчлал дэлхий нийтийн анхаарлын төвд байлаа. Ялангуяа Өрнөдийн орнууд энэхүү айлчлалыг Орос, Хятадын харилцааны шинэ эрин үеийн эхлэл боллоо гэж дүгнэж байна. Тэд ингэж үзэх

нь аргагүй. Энэхүү айлчлалын үеэр Орос, Хятад хоёр АНУ-ын “ганцаарчилсан тоглолтын” эсрэг хамтран тэмцэх болно гэдгээ ил тод илэрхийлсэн. Олон улсын харилцаанд АНУ-ын ноёлох байр суурь суларч, түүний эсрэг Хятад, Оросын хамтарсан үйл ажиллагаа эрчимжиж байгааг Америкийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд ч тэмдэглэж байна. Гэвч энэ бол Орос, Хятадын харилцааны шинэ үеийн эхлэл биш, харин стратегийн түншлэлийн харилцааны шинэ өрнөл, үргэлжлэл гэж үзэх нь илүү зохимжтой юм. Орос, Хятадын стратегийн түншлэлийн харилцаа өнөөдөр эхлээгүй гэдгийг бүгд мэдэж байгаа.

Хоёр орон өнөөгийн олон улсын харилцаанд өрнөж буй үйл явцын талаар ижил төстэй үзэл бодолтой байж, орчин үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нэгдмэл зарчмыг тууштай баримталж байна. Энэхүү зарчим нь Орос, Хятадын стратегийн ашиг сонирхолд бүрэн нийцэж байгаа бөгөөд түүнийгээ хамгаалахад бэлэн байгааг Өрнөдийн орнуудад харууллаа гэж үзэж болох юм. Улмаар АНУ-ын явуулж буй бодлогын улмаас нэгдмэл Европын эрин үе өнгөрч Европын орнууд Орос, Хятад, Евроазийн зүг эргэх үйл явц эхэлж буй бололтой.





Д.Баярхүү

Олон улсын харилцааны судлаач-проф

# НҮБ-ЫН НИЙТ ТӨСВИЙН 0.005 ХУВЬ МОНГОЛД НОГДДОГ

2019.05.07-нд НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас гишүүн орнууд НҮБ-ын төсөвт оруулдаг төлбөрөө тушааж байгаа байдлыг танилцуулжээ. Мөн өдрийн байдлаар 40 гаруй улс НҮБ-ын төсвийн төлбөр, бусад олон төрлийн зардлыг тогтсон цагт нь тоо ёсоор нь хуваан төлсөн гэсэн байна. Манай улс энд орсныг бүү мэд? Гэхдээ энэ сэдвийг хөндөө.

Манай улс НҮБ-ын татварт хичнээн төгрөг төлдөг бол? Жирийн монгол хүний санаанд энэ тухай сэтгэх цаг зав гарахгүй л дээ. Тэр мэдээж, албатай ч биш. Гэхдээ улсын нууц шахуу авч үздэг учраас тэр тоог нууцалдаг. Доллараар төлж таарна. Хэрэв ил зарлаад шилэн болгоод жил бүр мэдээлдэг болгочихвол нэг бодлын амар. Гэхдээ одоо цаг нь биш. Монголын гурван хүн тутмын нэг нь байнга шахуу ядуу зүдүү явдаг, аж төрөх гэж үхэлтэй нүүр тулж байгаа тул “НҮБ-д ямар их мөнгө өгдөг юм”, “ямар ашиг байна”, “яах гэж төлдөг юм”, “ядуурлыг бууруулахад НҮБ юугаар тусалсан юм” гэж ирээд л туйлшрахад манайхан яг

зэхээстэй байгаа. Надад болон миний амьдралд ямар ашигтай юм гэх шалгуур тавьдагийг нь буруутгах гээгүй.

Гэхдээ санааг нь амруулах ганцхан баримт дурдсу. Гишүүн орнуудын татвараас бүрддэг НҮБ-ын нийт төсвийн 0.005 хувийг Монгол Улс төлдөг юм шүү дээ. Үгчилбэл ТЭГ МЯНГАНЫ ТАВАН ХУВЬ. Ойролцоогоор 124.000 \$ жилдээ.

НҮБ руу орж тайлбар хайя. НҮБ-ын төсөв гэж ингэхэд юу юм бэ? Тэр нь тус байгууллагын байнгын төсөв; Энхийг сахиулах талаар явуулах ажиллагааны төсөв; Олон улсын эрүүгийн шүүхэд зориулах үлдэгдэл төсөв гэж гурван янз буй. НҮБ-ын Дүрмийн дагуу Ерөнхий Ассамблей төсөв хэлэлцэж батална, НҮБ-ын гишүүн орнуудад ногдох татварын хувь хэмжээг Ерөнхий Ассамблей гурван жилээр (жил бүр төд гэхчлэн) тогтоож өгнө. Захиргааны ба төсвийн асуудал эрхлэх зөвлөлдөх хороо гэж 18 гишүүнээс бүрдэх мэргэжилтний ажлын хэсгээс төсвийн төслийн анхны хувилбар бэлтгэгдэж, тэр нь Ерөнхий Ассамблейн 5

дугаар хороогоор хэлэлцэгдэнэ. Тус хороонд гишүүн бүх улс харьяалагдана. Энэ тухай [un.org/ru/ga/fifth](http://un.org/ru/ga/fifth) сайтаас тодруулж болно

Ногдуулсан татвараа цагтаа төлөөгүй, өр болж үлдсэн улс орнууд НҮБ-д санал өгөх эрхээ хасуулах хүртэл шийтгэлтэй. Ийм шийтгэлийн заналхийлэл дор манай улс нэг бус удаа нэр дурдагдаж анхааруулга авч байсан юм билээ.

НҮБ-ын төсвийг хоёр жилийн хугацаагаар баталдаг. Нэг санхүүгийн жил нь нэгдүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-нд үргэлжилнэ. 2018-2019 оны төсвийг 5.397 тэрбум ам.доллараар баталсан ба одоо хэрэгжиж байна. Юунд зарцуулах нь ойлгомжтой. Нью-Йорк дахь НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газар, Женев, Вена, Найроби дахь салбар төв офисуудын хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Мөн НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн комиссууд, бусад болон тусгай улс төрийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.



Санхүүжилтийн цаана гишүүн орнуудаас татварт хандивлах мөнгөн дүн их чухал. Хэн их мөнгө төлнө, тэр хэрээрээ НҮБ-д илүү эрх дарх эдэлнэ гэсэн бичигдээгүй дүрэм үйлчилнэ. Гишүүн орнуудын төлбөрийн чадвар, түүнийг тооцоолох шалгуур нь сүүлийн жилүүдийн макро эдийн засгийн үзүүлэлт, үндэсний нийт орлого, үндэсний валютынх ханшийн савалгаа, хүн ам тутамд ногдох үндэсний орлогын хэмжээ гэхчлэн олон хүчин зүйлээр тооцолж байж татварын хувь хэмжээ тодордог. Нэг улсаас НҮБ-ын татварын 22 хувиас дээш хувиар төлөхгүй байх, хамгийн ядуу гишүүн улс байлаа гэхэд ногдуулах татвар нь 0.001 хувиас буухгүй байхаар хязгаарласан. Нэг удаа АНУ 28.4691 хувийн татвар төлж байсан тохиолдол бий юм билээ.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганд оролцох хувь надад тохиож байсан ба тэр үед 2016-2018 оны төсөв баталж байхыг би сайн санаж байна. Тэр хуваарилалт одоо ч мөрдөгдөж байгаа болов уу. Ямар ч гэсэн өндөр татвар төлөгч эхний 10 гишүүн улс дээр ийм хувь хэмжээ гарч байсан даа.

№	Гишүүн улс	Татварын хувь
1	АНУ	22.000% буюу 22%
2	Япон	9.680
3	Хятад	7.921
4	Герман	6.389
5	Франц	4.859
6	Их Британи	4.463
7	Бразил	3.823
8	Итали	3.748
9	ОХУ	3.088 (одоо нэмэгдээд 3.9912 хувь болсон)
10	Канад	2.921
Нийлбэр	НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн улс	42.331 (Татварын бараг тал орчмыг нь)
Нийлбэр	Дээрхи 10 гишүүн улс	68.892 (Гуравны хоёр хувь)

Энхийг сахиулах ажиллагааны төсвийг нэг жилээр батлаж мөрдөнө. НҮБ-ын жил тутмын төсвөөсөө энэ төсвийг гаргаж ирэх учраас санхүүгийн жил нь жилийн хуанлийн 12 сараар байх албагүй. Жил бүрийн 7 дугаар сарын 1-нээс дараа жилийн 6 дугаар сарын 30-ны хооронд санхүүгийн жилээ тооцно. 2017-2018 оны

нэг жилд 6.8 тэрбум ам.доллар төсөвлөсөн. Герман энэ төсвийн 6.39 хувийг гаргасан, дэлхий дахинд энхийг сахиулахад мөнгөн хандив өргөсөн 4 дэх улс боллоо гэсэн мэдээ явж байсан.

Одоо яг хаана төсөв захцуулагдаж байна гэхэд жишээ татвал Сомалид материал-техникийн хангамжийн томхон бааз, Италийн Бриндизид

үйлчилгээний глобал төв, Испанийн Валенсид холбоо нөөц төв, Угандын Энтебб дэх бүс нутгийн үйлчилгээний төв, бусад үйл ажиллагаа гэхчлэн 7 316 тэрбум ам.доллар 2018.06.30 хүртэл зарцуулсан баримт буй. Энэ тухай [un.org/peacekeeping](http://un.org/peacekeeping); [peacekeeping.un.org](http://peacekeeping.un.org) гэх сайтуудад бичээтэй байна. Мөн [unmissions.org](http://unmissions.org) сайтаас мэдээлэл авч болно.

Уг төсөвт НҮБ-ын бүх гишүүн улсууд татвараа хандивлана. Татварын хувь хэмжээ гэж тогтооно. Татвар төлөлөгчдийг гурван бүлэгт хуваана. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүд—олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд онцгой хариуцлага үүрдэг гэдгээрээ энэ 5 улсад ногдуулах татвар өндөр; хоёр дахь бүлэг нь хөгжингүй орнуудаас бүрдэх ба НҮБ-ын байнгын төсөвт төлдөг шигээ хэмжээний татвар энхийг сахиулахад төлнө; гурав дахь бүлэг орнуудад хөгжиж буй орнууд орох ба дотроо хэд хэдэн салбар бүлэгтэй, учир нь хөгжлийн ялгаа зөрүү бий гэдгээрээ ангилагддаг. Гэхдээ НҮБ-ын байнгын төсөвт төлдөгөөсөө багыг төлнө.

Олон улсын эрүүгийн шүүхэд зориулах төсөв гэдэг нь хоёр жилийн хугацаагаар батлагдана. Жилийн эхний өдрөөс сүүлчийн өдөр хүртэл мөрдөгдөнө. Өмнө нь Руандагийн талаар ажилласан олон улсын эрүүгийн шүүх, хуучин Югославын талаархи олон улсын шүүхийн зардалд төсөв нь үлэмж зарцуулагдаж байсан. 2016-2017 онд 131.97 сая ам.доллар төсөвлөсөн, 2018 онд зарцуулсан нь үлэмж хязгаарлаад 87.79 сая доллар байсан. Төсвийг бүрдүүлэхдээ арифметикийн дундаж хэмжээгээр улсуудад хуваарилан хувь тогтооно.

Ингэхэд татвараа цагт нь төлөөгүйн төлөө Ерөнхий Ассамблейд санал хураалтад оролцох эрхээ хасуулж байсан тохиолдол бий болов уу? Энэ тухай НҮБ-ын Дүрмийн 19 дүгээр заалт гэж бий. Өмнөх түүхэнд байсан уу гэвэл байсан юм билээ. 2018.09.25-ны байдлаар гурван улс татварын төлбөрийн тооцоотой хэмээгдэн санал хураалгах эрхээ хасуулж байжээ. Тэдгээр нь 1. Коморын арлууд, 2. Сан-Томе ба Принсипи, 3. Сомали улс ажээ.

Манай улс арай ч ийм дээрээ гулахгүй, тэр мэдээж. Гэхдээ татвар төлөх нь гарцаагүй. Өртэй үлдэж болохгүй. Жилдээ ойролцоогоор 124 мянган ам.доллар төлж байгаа нь нэг хэсэгтээ үргэлжилнэ. Харин ШХАБ мэтийн бүс нутгийн олон улсын байгууллагад элсвэл төлөх татвар нь энэ дүнгээс даруй 2 дахин, түүнээс ч илүү даваад явчих магадлалтай.

Ингэхэд НҮБ-ын татвар бүрдүүлэлт дээр БНХАУ идэвхийлээд байгаад анхаарал хандуулах хэрэгтэй. Дэлхий нийтээрээ л тэгж байна. Өөрсдийгөө хөгжиж байгаа орон гэж нэрлэх, тэгсэн хэрнээ аж үйлдвэржсэн хөгжингүй орнуудыг ардаа орхиод татвар төлөлтөөс манлайлаад эхэлсэн, гайхаш бараад ч байх шиг.

НҮБ-ын төсөв бүрдүүлэлт дээр Герман, Франц, Британийг алгасаад явчихсан, одоо гуравт бичигдэж байгаа нь тус улсын жин нөлөө, дуу хоолой дэлхийн хамтын нийгэмлэгт нэмэгдэж байна, нэмэгдэх ч болно. Тун удахгүй НҮБ-ын ЕНБД-ын орлогч, төрөлжсөн байгууллагуудын даргаар хятадын дипломатч сонгогдоод гараад ирэхэд гайхах зүйлгүй болж байх шиг.

Хятадын зарим хэвлэлд

НҮБ-д төлдөг татварынх нь тухай элдэв мэдээ нийтлэгддэг болсон. Хандив нь ч ил зарлагддаг. ISIL-ийн эсрэг олон улсын эвсэлд Хятад мэдээж орохгүй, харин олон улсын терроризмын эсрэг дэлхий дахины тэмцэлд 100 сая ам.доллар хандивлалаа хэмээн тус улсын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көцян НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган дээр ёслол төгөлдөр зарлаж байсныг бид мэднэ. Хятадын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Хуа Чүнъин ингэж ярьж байна. Юу гэвэл НҮБ-ын төсөв бүрдүүлэх гол зарчим бол гишүүн орнуудын төлбөрийн чадвараас шалтгаалдаг. Хятадын эдийн засгийн ерөнхий потенциал их боловч нэг хүн ам тутамд ногдох орлогын түвшин доогуур, тэгэхлээр хөгжиж буй орон хэвээрээ байна. Энэ бол Хятад хувьд төлбөр тооцоо хийх чадварын гол үндэс болно гэжээ. Тэгснээ Хятад нь НҮБ-ын байнгын төсвийн хөрөнгө нийлүүлэгч хоёр дахь том гишүүн-улс (АНУ-ын араас), мөн энхийг сахиулах төсвийг бүрдүүлэгч хоёр дахь том нь (мөн АНУ-ын дараа) болсон гэжээ. “НҮБ-ын саяхан баталсан шийдвэрээр ирэх гурван жилд Хятад нь НҮБ-ын байнгын төсөв, энхийг сахиулах төсвийн зардлыг бүрдүүлэх хэмжээгээ эрс нэмэгдүүлж, байнгын төсвийн 12 хувь, энхийг сахиулах төсвийн 15.2 хувийг тус тус бүрдүүлэх боллоо. Энэ бол Хятад нь дэлхийн хоёр дахь том эдийн засаг (эдийн засгийн цогц хэмээн өөрсдөө нэрлэдэг) болж, эдийн засгийн ерөнхий хэмжээ дамжаа, хүн нэг бүрт ногдох улсын эдийн засаг нэмэгдсэний үр дүн, мөн Хятадын олон улсын нэр нөлөө нэмэгдсэний илэрхийлэл мөн” гэжээ.



**Ч.Баатар**  
ОББЭЭС

## БРЕКСИТИЙН ҮЙЛ ЯВЦ

Их Британийн Ерөнхий сайд Дэвид Камерон Их Британи, Умард Ирландийн Нэгдсэн Вант Улс Европын Холбоонд үлдэх эсэх асуудлаар үндэсний хэмжээний референдум явуулахаа 2013 онд амласан байдаг. Уг референдумыг 2016 оны 6 дугаар сарын 23-нд явуулахад санал өгөх эрхтэй хүмүүсийн 71.8 хувь буюу 30 гаруй сая хүн санал өгснөөс 51.9 хувь нь гарахын төлөө, 48.1 хувь нь үлдэхийн төлөө саналаа

өгсөн. Англи 53.4/46.6, Уэльс 52.5/47.5 хувиар ЕХ-ноос гарахын төлөө санал өгсөн бол Шотланд 62/38, Хойт Ирланд 55.8/44.2 хувиар ЕХ-нд үлдэхийн төлөө саналаа өгсөн.

Европын Холбооноос гарах асуудал Европын Холбооны талаархи Гэрээний 50 дугаар зүйл буюу заримдаа Лисбоны гэж нэрлэгддэг Гэрээгээр зохицуулагддаг байна. Лисбоны Гэрээний 50 дугаар заалтын дагуу гарах нөхцлийг тохиролцоход хоёр талд 2

жилийн хугацаа өгсөн. Ерөнхий сайд Тереза Мэй ЕХ-ноос гарах үйл явцыг 2017 оны 3 дугаар сарын 29-нд эхлүүлсэн. Тиймээс Их Британи ЕХ-г 2019 оны 3 дугаар сарын 29 гэхэд орхих ёстой гэсэн хэрэг юм. Тереза Мэй Их Британи ЕХ-ноос гарахыг 2018 оны 6 дугаар сард хуульчилсан болно.

Европын Шүүх ЕХ-ноос гарах үйл явцаа Их Британи зогсоож болно гэсэн шийдвэр гаргасан. Мөн ЕХ-ны 28

гишүүн бүгд зөвшөөрвөл гарах хугацааг сунгаж болох юм. Тиймээс Их Британи ЕХ-ноос гарах үйл явцыг зогсоохын тулд хуулиа өөрчлөх ёстой болно.

Ийнхүү Их Британи ЕХ-той олон сар хэлэлцээ хийсний эцэст ЕХ-ноос гарах нөхцлийн талаар тохиролцоонд хүрсэн. Нийт 585 хуудас бүхий Гарах Хэлэлцээрт гарын үсэг зурсан. Их Британи ЕХ-ноос гарахдаа 39 тэрбум еврогийн төлбөр өгөх үүрэг хүлээсэн. ЕХ-нд амьдарч байгаа англи иргэд болон Их Британид амьдарч байгаа ЕХ-ны гишүүн орнуудын иргэдийн талаар тохирсон. Мөн Хойт Ирландийн 310 милль хилийн талаар тохирсон. Их Британи ЕХ-ноос гарсан тохиолдолд ЕХ-ны гишүүн БН Ирланд улс болон Хойт Ирландын хооронд хилийн хяналтын цэг, хилийн цамхаг, гаалийн нэвтрүүлэх цэг, хяналтын камерууд г.м. хилийн биет зүйлийг дахин сэргээхгүй гэж ЕХ-той тохирсон. ЕХ болон Их Британий худалдааны яриа хэлэлцээний дүн ямар ч байлаа гэсэн “хатуу хил” байхгүй гэж тохиролцсон.

Тереза Мэйгийн ЕХ-ноос гарах нөхцлийн талаар тохирсон Хэлэлцээрийг Английн парламентад таван өдрийн турш хэлэлцсэний эцэст 2019 оны 1 дүгээр сарын 15-нд санал хураалт явуулсан. Ерөнхий сайд Тереза Мэйгийн тохиролцоог парламентийн гишүүд 202:432-ын саналаар хүлээн авахаас татгалзсан. Энэ саналын зөрүү нь Мэйг

дэмжигчдийн саналаас ч /202:230/ олон байгаа юм. Энэ нь Их Британийн 19 дүгээр зуунаас хойшхи түүхэнд байгаагүй том ялагдал болсон. Энэ үйл явц нь ЕХ-ноос гарахаас 10 долоо хоногийн өмнө болсон хэрэг юм. Энэ ялагдалтай холбогдуулан Хөдөлмөрийн Намын лидер Жереми Корбин Ерөнхий сайд Тереза Мэйд үл итгэх санал хураалт явуулахыг шаардсан. Ингээд 1 дүгээр сарын 16-ны Лхагва гаригт Үл итгэх санал хураалт болж Тереза Мэй 325:306-ийн харьцаагаар буюу 19 саналын зөрүүгээр ялалт байгуулж Засгийн газраа хадгалж үлдэж чадсан юм. Английн судалгааны институт болох “Европын шинэчлэлийн Төв”-ийн орлогч захирал Спрингфорд /Springford/ “Мэй ЕХ-ноос гарах үйл явцын хяналтаа бүрэн алдлаа. ЕХ-ноос гарах түүний нөхцлийн хувилбар 230 саналын зөрүүтэй ялагдсан нь энэ хувилбар бүрэн үхмэл байдалд орсон хэрэг юм” гэж дүгнэсэн юм.

ЕХ-ноос гарах Мэйгийн нөхцлийг Их Британийн парламент дэмжсэн тохиолдолд “Шилжилтийн үе” гэж зүйл үйлчлэх байв. Энэ нь ЕХ-ноос гарснаас хойшхи 3 жил орчмын хугацаанд ЕХ болон Их Британи хоорондын цаашдын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын талаар тохиролцоо ёстой үе байв.

ЕХ-ноос гарах Хэлэлцээрийн талаар хоёрдох санал хураалтыг Мэйгийн Засгийн газар 3 дугаар сарын

14-нд парламентад явуулахад 242:391 саналаар дахин ялагдсан. Тереза Мэй Лисбоны 50 дугаар зүйлийн хугацааг 2019 оны 6 дугаар сарын 30 хүртэл сунгаж өгөхийг ЕХ-нд хүсэлт болгосон. ЕХ хэрэв Их Британы парламент Гарах Хэлэлцээрийг 2019 оны 3 дугаар сарын 29-ноос өмнө баталбал хугацааг 2019 оны 5 дугаар сарын 22 хүртэл сунгахаа мэдэгдсэн. Гарах Хэлэлцээрээс Улс төрийн Тунхаглалыг нь тусгаарласан хувилбараар парламентад 4 дүгээр сарын 5-нд санал хураалгахад Мэйн Засгийн газар 286:344 саналаар дахин ялагдал хүлээсэн. ЕХ 4 дүгээр сарын 10-нд 50 дугаар зүйлийн хугацааг Их Британи 5 дугаар сард болох Европын Парламентийн сонгуульд оролцсон тохиолдолд 2019 оны 10 дугаар сарын 31 хүртэл хоёрдох удаагаа сунгахаар болсон.

Ерөнхий сайд Тереза Мэй ЕХ-ноос гарах тохиролцоог парламентаараа батлуулж чадаагүй болон хэд хэдэн удаагийн Үл итгэх санал хураалтад орсонтойгоо уялдан Консерватив намын лидерээсээ 6 дугаар сарын 7-ноор тасалбар болгон бууж байгаагаа 5 дугаар сарын 24-нд зарлан намын шинэ лидер гарч ирэх хүртэл хугацаанд Ерөнхий сайдын үүрэгт ажлаа үргэлжлүүлэн хийхээ мэдэгдсэн.

Их Британи ЕХ-ноос гарсан тохиолдолд эдийн засагт ямар хохирол учирч болох талаар янз бүрийн судалгаа,



дүгнэлтүүд гарсаар байна. Нэг хүнд ногдох бодит орлого дунд болон удаан хугацаандаа буурна гэж тооцож байна. Их Британий ДНБ-ний алдагдлыг 2-2.5 хувьд хүрнэ гэж үзэж байна. Энэ нь 2.6 их наядын эдийн засагтай улсад 58-73 тэрбум долларын алдагдал гарна гэсэн үг юм. Английн “Төсвийн судалгааны Институт”-ийн судалгаагаар Их Британийн эдийн засгийн өсөлт буурснаар 70 тэрбум фунтийн алдагдал хүлээх аюултайг анхааруулсан. Их Британийн Сангийн Яам ЕХ-ноос гарснаас хойш 15 жилийн дараа гэхэд эдийн засаг ЕХ-нд байхтай харьцуулбал 3.9 хувиар буурна гэсэн тооцоог хийсэн. Их Британид аль хир их алдагдал учирах нь тус улс ЕХ-ноос “хатуу” буюу хүндрэлтэй гарах уу, эсвэл “зөөлөн” буюу аядуу гарах уу гэдгээс ихээхэн хамаарна гэж үзэж байна. “Хатуу” гэдэг

нь гарах нөхцлийн талаар ЕХ-той тохиролцож чадалгүй түүнийг орхих, худалдаагаа ДХБ-ын дүрэм журмаар явуулахыг үндсэнд нь ойлгож байгаа болно. “Зөөлөн” гэдэг нь тохиролцсон нөхцлөөр ЕХ-ноос гарах, Европын нэгдмэл зах зээлд гишүүнчлэлээ хэвээр хадгалах, “Гаалийн Холбоо”-нд үлдэх, Европын эдийн засгийн хүрээний дүрмийн дагуу хүмүүсийн чөлөөт шилжилтийг тодорхой хэмжээгээр хадгалахыг хэлж байгаа болно.

Их Британи ЕХ-оог орхих нь мөн ЕХ-нд ч хохиролтой юм. ЕХ хоёрдогч том эдийн засгийг алдах, хүн амын тоогоор гуравт ордог улсаа алдах, “дэлхийн санхүүгийн төв”-ийг алдах юм. ЕХ-ны төсөвт оруулдаг хувь хэмжээгээрээ хоёрт ордог /2015 оны байдлаар Герман-14.3 тэрбум евро, Их Британи- 11.5 тэрбум евро, Франц- 5.5 тэрбум евро / улсаа

алдаж байгаа хэрэг юм. Мөн Европын Хөрөнгө оруулалтын Банкны хувьцааны 16 хувь буюу 39.2 тэрбум еврогийн хувьцаа эзэмшигч байхаа больж хөрөнгөө татаж авна гэсэн үг юм.

Одоогоор Их Британийн Консерватив намын лидерийг тодруулах сунгаа ид явагдаж байгаа бөгөөд Лондон хотын мэр байсан, Гадаад хэргийн сайд асан Борис Жонсон, Гадаад хэргийн сайд Жереми Хант хоёр тунаж үлдээд байна. Судлаачид Борис Жонсоныг ялах магадлал илүүтэй гэж үзэж байгаа. Тэрээр Их Британийг ЕХ-ноос гаргахыг тууштай дэмжигч нэгэн билээ. Тэрээр ялж гарч ирчихээд Их Британийг ЕХ-ноос “хатуу” байдлаар буюу тохиролцоогүй гаргахаар зүтгүүлбэл түүнд Үл итгэх санал хураалт явагдах өндөр магадлалтай гэж судлаачид үзэж байна.

# ҮЙЛ ЯВДЛЫН ХЭЛХЭЭС

## 2019 ОНЫ 6 ДУГААР САР

### 12-НЫ ӨДӨР

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Бүгд Найрамдах Киргиз Улсад 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдөр албан ёсны айлчлал хийв. Айлчлалаар харилцааны түвшинг шат ахиулахаар тохирч, хамтын ажиллагааг цаашид худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт түлхүү хөгжүүлэх талаар санал солилцов. Мөн Айлчлалын үеэр Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух ЭСЯ-ны нээлтийн ажиллагаа боллоо.

### 13-14-НИЙ ӨДРҮҮДЭД

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Бүгд Найрамдах Киргиз Улсын Бишкек хотноо 6 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн хуралдаанд оролцож, 6 дугаар сарын 14-ний өдөр болсон Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн тэргүүн нарын тавдугаар уулзалтыг даргалав.

### 23-26-НЫ ӨДРҮҮДЭД

Швейцарийн Холбооны Улсын Үндэсний зөвлөлийн дарга Марина Кароббио Гүшэтти Монгол Улсад 6 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийв.

### 6-8-НЫ ӨДРҮҮДЭД

Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин 6 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд ОХУ-ын Санкт-Петербург хотноо болсон Петербургийн 23 дахь удаагийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцов.

### 14-15-НЫ ӨДРҮҮДЭД

Бүгд Найрамдах Армени Улсын Үндэсний Ассамблейн Дэд дарга М.Мелкумян тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад 6 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд ажлын айлчлал хийв.

### 20-22-НЫ ӨДРҮҮДЭД

ЕАБХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Т.Гремингер Монгол Улсад 6 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд ажлын айлчлал хийж, “Терроризмд турхирч буй хүчирхийлэл дагуулсан экстремизм, радикалчлалаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд нийгмийг хандуулах нь” сэдэвт бүс нутгийн дээд хэмжээний бага хуралд оролцов.

### 6-7-НЫ ӨДРҮҮДЭД

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Бүгд Найрамдах Сингапур Улсад 6 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийв.

### 15-17-НЫ ӨДРҮҮДЭД

Япон Улсын Гадаад хэргийн сайд Коно Таро Монгол Улсад 6 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийв.

**20-21-НИЙ  
ӨДРҮҮДЭД**

Унгар Улсын Гадаад хэрэг, худалдааны сайд П.Сияяарто Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд болсон “Терроризмд турхирч буй хүчирхийлэл дагуулсан экстремизм, радикалчлалаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд нийгмийг хандуулах нь” сэдэвт бүс нутгийн дээд хэмжээний бага хуралд оролцож, манай улсад ажлын айлчлал хийв.

**5-6-НЫ  
ӨДРҮҮДЭД**

“Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын 6 дугаар бага хурлыг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд 1.5 сувгийн түвшинд зохион байгуулав. Бага хуралд Монгол Улс, ОХУ, БНХАУ, Япон Улс, БНСУ, АНУ, Британи, Канад, Нидерланд, Норвеги, ХБНГУ, Франц, Швейцарь, Европын Холбоо, мөн НҮБ-ын системийн байгууллагууд, бусад олон улсын байгууллага, судалгааны хүрээлэн, дотоодын төр, хувийн хэвшлийн нийт 200 гаруй төлөөлөгч оролцов.

**4-НИЙ  
ӨДӨР**

Монгол, Канадын Засгийн газар хоорондын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдаан Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 4-ний өдөр болж өнгөрөв.

**26-27-НЫ  
ӨДРҮҮДЭД**

Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны 19 дүгээр хуралдаан Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд болов.

**26-НЫ  
ӨДӨР**

Монгол Улс, Европын Холбооны Худалдаа, хөрөнгө оруулалтын дэд хорооны хуралдааныг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав.

**24-25-НЫ  
ӨДРҮҮДЭД**

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Болгарын Засгийн газар хоорондын комиссын 7 дугаар хуралдааныг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулав.

**28-НЫ  
ӨДӨР**

Монгол, Беларусийн ЗГХК-ын 5 дугаар хуралдааныг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулав.

Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны 4 дүгээр хуралдааныг Сөүл хотноо 6 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан.

**27-НЫ  
ӨДӨР**

Гадаад харилцааны яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн газартай хамтран “Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны форум-2019”-ыг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа.

**24-НИЙ  
ӨДӨР**

“Монгол Улсад 2017-2021 онд НҮБ-аас үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” баримт бичгийн хэрэгжилтийг хянан хэлэлцэх Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хамтарсан Удирдах хорооны хурлыг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулав.